



Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас

Бүлэг сэдэв: **Амьдрал**

Дэд сэдэв: **Цэцэгт ургамлын амьдралын эргэлт**- Ургал эрхтэн гэж юу вэ?

Анги: **5 дугаар анги**

Даалгавар	Хариултын мэдээлэл	Буруу хариултын шинжилгээ
1. Ойлгох түвшин	Даалгавар 1 Ургамал ургахад хэрэгтэй хүчин зүйлсүүд юу вэ? Нэрлэн бичээрэй. 	
2. Ойлгох түвшин	2. Ургамлын эрхтнүүдийг ургал эрхтэн ба үржлийн эрхтэн гэж ангилдаг. Дараах өгүүлбэрийг анхааралтай уншаад ургамлын эрхтнүүдийг ургал болон үржлийн аль нь болохыг ялган холбоорой. 	
3. Ойлгох түвшин	3. Бид хоол хүнсэндээ олон төрлийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ хэрэглэдэг. Дараах ургамлын зургийг ажиглаад яг ямар эрхтнийг нь хүнсэндээ хэрэглэдэг болохыг нь нэрлээд ургал болон үржлийн эрхтний аль нь болохыг ялган холбоорой. Загварыг ашиглаарай. 	

4.
Задлан
шинжлэх
түвшин

4. QR кодыг уншуулан бичлэгийг үзээд ургамлын амьдралын эхний 10 хоногт гарч байгаа өөрчлөлтийг зурж, тайлбар бичээрэй.



Ургамлын үр соёолж ургаж байгаа үйл явцыг эдгээр дарааллын дагуу зураад тайлбарлана.

Бүлэг сэдэв: **Амьдрал**

Дэд сэдэв: **Цэцэгт ургамлын амьдралын эргэлт**- Үр соёолох гэж юу вэ?



Анги: **5 дугаар анги**

1. Ойлгох түвшин	1. Үр соёолох үйл явцтай холбоотой өгүүлбэрийг зөв дараалалд оруулан 1,2,3 тоогоор дугаарлаарай. 1 Үр соёолох үйл явцтай холбоотой өгүүлбэрийг зөв дараалалд оруулан 1,2,3 тоогоор дугаарлаарай. 2 Нахиа гэрлийн зүг ургадаг. 1 Жижиг үндэс нь газрын гүн рүү чиглэн ургадаг. 3 Навч ургаж эхэлдэг. 	
2. • Задлан шинжлэх	2. Энхжин, Мөнхжин, Халиун гурав тус бүр 10 шошны үр соёолуулахаар туршилт хийжээ. Тэд адилхан шилэн тавганд хөвөн дэвслээ. / 3 хүүхдийн үр хэрхэн соёолсныг дүгнэн бичих/ ❖ Энхжингийн тарьсан үр соёолсон боловч үр дүн тийм сайн биш. Учир нь Энхжин бүрхсэн скочийг цоолж нүх гаргаагүй учир агаар дутсан байна. ❖ Мөнхжингийн тарьсан үр ихэнх үр соёолсон байна. Учир нь Мөнхжин үрээ чийглээд скочийг жижиг цоолсон тул агаартай байсан. Халиуны тарьсан үр ургаагүй муудсан байна. Учир нь ус чийг нь хэт ихэдсэн байна.	
3. • Хэрэглэх түвшин	3. Багш сурагчдад вандуйн үрийг соёолуулах туршилт хийх даалгавар өгчээ. Дараах QR кодыг уншуулан, бичлэгийг үзээд найздаа үрийг соёолуул ахын тулд юуг анхаарах талаар зөвлөмж бичээрэй. Зөвлөмж Аливаа үрийг соёолуулахыг тулд ус, чийг, агаар, ургах орчин, гэрэл заавал хэрэгтэй. Тийм болохоор салфеткан цаас болон хөвөнг бага зэрэг чийглээд түүн дээр үрээ цацаад бага зэрэг агаар орохоо шилэн таг болон гялгар цаасаар бүрээд дулаан нартай газар байрлуулна.	
4. Задлан шинжлэх түвшин	4. Үрээс үндэс гарахыг үр соёолох гэнэ. Үр соёолоход ямар хүчин зүйлүүд нөлөөлсөн бэ? чи найздаа юу гэж зөвлөсөн бэ? бичээрэй. УС ЧИЙГ, АГААР, ДУЛААН	

Бүлэг сэдэв: **Амьдрал**

Дэд сэдэв: **Цэцэгт ургамлын амьдралын эргэлт**- Ургамлыг ургал эрхтэнээр үржүүлэх арга


Анги: **5 дугаар анги**

1. ойлгох түвшин	1. Зурагт ургамлыг ишээр хэрхэн үржүүлж болох дарааллыг харуулсан байна. Доор бичсэн өгүүлбэрүүдэд тохирох зургийн үйл явдлын дугаарыг зөв сонгож тэмдэглээрэй.  1 Цэцэггүй 2-5 навч, нахиа бүхий мөчир сонгон авна. 7 Үндэслэсэн мөчрийг үржил шим сайтай хөрсөнд суулгана. 3 Сонгосон мөчрийнхөө доод үзүүрийг ташуу огтолно. 6 Хэд хоногийн дараа мөчир үндэслэж бие даан ургах чадвартай болно. 4,5 Огтлосон мөчрөө усанд хийж үндэслүүлнэ.	
2. Задлан шинжлэх түвшин	“Мөнхрөө” тасалгааны ургамлыг хэрхэн үрслүүлж ургуулах вэ? QR кодыг уншуулан бичлэгийг үзээд, үрслүүлж ургуулахад анхаарах 2 гол зүйлийг найздаа зөвлөөрэй. Зөвлөмж Мөнхрөөг ургал эрхтэн болох навчаар нь үржүүлдэг. Навчийг тайраад шууд хөрсөнд суулгаж болно. Усанд үндэслүүлээд суулгаж бас болно...	
3 Задлан шинжлэх түвшин	3 Дараах зураг тус бүрийг ажиглаад ямар ургал эрхтнээр нь үржүүлсэн болохыг нэрлээрэй.  ИШ НАВЧ ИШ НАВЧ	

Бүлэг сэдэв: **Амьдрал**

Дэд сэдэв: **Цэцэгт ургамлын амьдралын эргэлт**

Анги: **5 дугаар анги**

1. Хэрэглэх түвшин	Даалгавар 1 Зургаас шошийн ургалтын үе шатуудыг ажиглаад зөв дараалалд оруулан дугаарлана уу. 	
2. • Задлан шинжлэх түвшин	2 Цэцэгт ургамлын амьдралын үе шатыг дарааллын дагуу зөв нэрлээрэй. 	
3. • Задлан шинжлэх түвшин	3 Ургамлыг бид амьдралдаа хэрхэн ашигладаг вэ? Оюуны зураглалыг гүйцээн бичээрэй. 	